



117  
106

## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 032

Улаанбаатар хот

### ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Имж  
с/б  
/2

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.10, Мэдээллийн технологийн үндэсний паркийн дүрмийн 8-р зүйлийн 8.5.8, Хөдөлмөрийн дотоод журмын 7-р зүйлийн 7.1.1-р заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Мэдээллийн технологийн үндэсний паркийн “Инкубаторын компаниудын үйл ажиллагаанд сар тутам хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

Хоёр. Журмын хэрэгжилтийг ханган ажиллах төлөвлөгөө гарган ажиллахыг Инкубатор, бизнес хөгжүүлэлтийн төв /П.Наранцэцэг/-д даалгасугай.

Гурав. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулж байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар/Ц.Эрдэнэлхам/-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Б.МЯГМАРНАРАН

215  
107



Мэдээллийн технологийн үндэсний Паркын Ерөнхий захирлын 2015 оны 02 сарын 24 өдрийн 022 тоот тушаалын хавсралт

## ИНКУБАТОРЫН КОМПАНИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД САР ТУТАМ ХЯНАЛТ ТАВЬЖ, ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ӨГӨХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Мэдээллийн технологийн инкубаторын компаниудын инкубаторт элсэхдээ дэвшүүлсэн 2,5 жилийн бизнес төлөвлөгөөний биелэлтэнд байнга хяналт тавьж, тэдэнд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор МТҮП-аас сарын үнэлгээ хийхэд энэхүү журмыг баримтална.
- 1.2 Мэдээллийн технологийн инкубаторын үйл ажиллагааны журмын дагуу Мэдээллийн технологийн үндэсний парк /МТҮП/-ын инкубатор хариуцсан мэргэжилтнүүд нь инкубаторын компаниудын тухайн сарын үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 1.3 Компанийн үйл ажиллагаанд сар тутам хяналт тавих үзүүлэлтүүд нь сарын үнэлгээний үндэслэл болно.

### Хоёр. Сарын үнэлгээний үзүүлэлт

2.1 Дараах үзүүлэлтүүдээр мэдээллийн технологийн инкубаторын компаниудын үйл ажиллагаанд сар тутам хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгнө.

№	Үзүүлэлт	Дүгнэх аргачлал
<b>А. Үйл ажиллагааны үзүүлэлт</b>		
1	Бизнес төлөвлөгөөний биелэлт, явц /төлөвлөсөн ажлын гүйцэтгэл/ (W1)	Хагас жилд төлөвлөсөн ажлын тухайн сард оногдох ажлууд ямар гүйцэтгэлтэй байна, бүрэн биелсэн эсэх, дуусаагүй үргэлжлэх ажлын хувьд хэдэн хувь нь биелсэн байх ёстойг хянаж, гүйцэтгэлийн тоо хэмжээ, чанарт үнэлгээ өгнө
2	Бүтээгдэхүүний хөгжүүлэлт (W2)	Компанийн шинээр үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн/үйлчилгээний хөгжүүлэлтийн байдлыг үндэслэн үнэлгээ өгнө. /инновацид чиглүүлж байгаа эсэх, эх загвар, тест, туршилтын үе шатны шаардлагыг хангаж байгаа эсэх/
<b>Б. Эдийн засгийн үзүүлэлт</b>		
3	Түрээсийн төлбөрийн чадамж (M1)	Гэрээний хугацаанд төлбөр төлөгдсөн эсэх;
4	Цалин олголт, НДШ, НӨАТ болон бусад татвар төлөлт (M2)	Холбогдох хуульд заасан хугацаанд татвар, НӨАТ, НДШ-ийн тайланг илгээсэн эсэх, цалингаа олгож буй эсэх;
5	Санхүүгийн тайланг үнэн зөв	Тайлангийн мэдээг хугацаа хоцруулахгүй орлого,

	гаргаж, цаасан хэлбэрээр өгөх (M3)	зарлагын задаргааг зөв тайлагнасан эсэх;
В. Үүрэг хариуцлагын үзүүлэлт		
5	Хамтын ажиллагааны гэрээний биелэлт (N1)	Хамтын ажиллагааны гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг дүгнэнэ;
6	Хөдөлмөрийн харилцаа, албан бичиг хөтлөлт (N2)	Хөдөлмөрийн хууль болон хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээний биелэлт хангагдаж буй эсэхийг дүгнэнэ;
7	Дүрэм, журмын мөрдлөг (N3)	Үйл ажиллагаагаа явуулахдаа холбогдох дүрэм журмыг зөрчилгүй ажиллаж буй эсэхийг дүгнэнэ;

### Гурав. Сарын үнэлгээ хийх

3.1 Компани бүрийн тухайн сарын үйл ажиллагаанд үнэлгээ хийхдээ А, В, С, D, F гэсэн 5 шатлалаар дүгнэнэ. Үсгэн дүнгийн ард дугуй хаалтанд тоон дүнг хамт бичнэ. Үүнд:

Үсгэн үнэлгээ	Оноо /хувь/
А	90-100
В	80-89
С	70-79
D	60-69
F	0-59

3.2 Үсгэн дүнгийн ард дугуй хаалтанд тоон дүн тавиагүй байвал үсгэн дүнд харгалзах дундаж оноогоор тооцож үнэлнэ.

3.3 Хяналт тавьж, үнэлэх дүнгийн үзүүлэлтүүд нь дараах жингийн коэффициенттой байна.

Үзүүлэлт	Эхний жилд	Сүүлийн нэг жил хагаст
Үйл ажиллагааны үзүүлэлтийн жингийн коэф (α)	0,5	0,3
Эдийн засгийн үзүүлэлтийн жингийн коэф (β)	0,1	0,3
Үүрэг хариуцлагын үзүүлэлтийн жингийн коэф (γ)	0,4	0,4

3.4 Голч оноог бодож гаргахын тулд шалгуур үзүүлэлт тус бүрт дараах жингийн коэффициентийг ашиглана. Үүнд:

А) Үйл ажиллагааны үзүүлэлт

- Бизнес төлөвлөгөөний биелэлт, явц /Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл/ 0.6
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлт 0.4

Б) Эдийн засгийн үзүүлэлт

- Түрээсийн төлбөрийн чадамж 0.2
- Цалин олголт, НДШ, НӨАТ болон бусад татвар төлөлт 0.5

- Санхүүгийн мэдээг үнэн зөв хугацаандаа ирүүлсэн 0.3

В) Үүрэг хариуцлагын үзүүлэлт

- Хамтын ажиллагааны гэрээний биелэлт 0.4

- Хөдөлмөрийн харилцаа, албан бичиг хөтлөлт- 0.3

- Дүрэм журмын мөрдлөг – 0,3

3.5 Үзүүлэлтүүдийн дүнг нэгтгэж, тухайн компанийн голч оноог тооцохдоо дараах томъёог ашиглана.

$$G = \alpha (0.6W_1 + 0.4W_2) + \beta (0.2M_1 + 0.5M_2 + 0.3M_3) + \gamma (0.4N_1 + 0.3N_2 + 0.3N_3)$$

Үүнд:

G- Голч оноо

$W_1, W_2, W_3$ - Үйл ажиллагааны үзүүлэлт тус бүрт өгсөн дүн

$M_1, M_2, M_3$ - Эдийн засгийн үзүүлэлт тус бүрт өгсөн дүн

$N_1, N_2, N_3$  - Үүрэг хариуцлагын үзүүлэлт тус бүрт өгсөн дүн

Өгөх үнэлгээ:

$G > 90$  бол маш сайн (A)

$80 < G \leq 90$  бол сайн (B)

$70 < G \leq 80$  бол дунд (C)

$60 < G \leq 70$  бол хангалттай (D)

$G \leq 60$  бол муу (F)

3.6 Инкубаторын компаниудын сарын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгсөн дүн, тэмдэглэлийг байгууллагын нууцын зэрэглэлд хамааруулна.